
НӨЛӨӨЛЛИЙН АЯН · 2026 оны 9-р сарын 8

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ 2333 ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЖЭЭ



Прокурорын байгууллага сүүлийн 5 жилийн байдлаар Хүрээлэн байгаа орчны эсрэг 4105 гэмт хэрэгт хяналт тавьж, 2333 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн. Үүнээс 41 хувийг Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг эзэлж байна.

Сүүлийн 2 жилд шүүхээс 1228 хүн, 18 хуулийн этгээдийг гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэснээс 13 нь БНХАУ, ОХУ, Тайвань, Казакстан зэрэг гадаад улсын иргэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн 797 хэргийн улмаас байгаль орчинд 25 тэрбум төгрөгийн хохирол учирснаас, 6,09 тэрбум төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=ZtNAL3uI-Cw